

## Яагаад хүн төрөлхтөн байх болсон бэ

Юуны өмнө та бүхэнд Хятадын шинэ жилийн баярыг тохиолдуулан мэнд дэвшүүлье!

Шинэ оны үеэр уг нь хүн бүрийн сонсох дуртай шинэ жилийн мэндчилгээг хэлэх ёстой байсан ч, аюул хүн төрөлхтөнд алхам алхмаар ойртож байгааг би харж байна. Энэ шалтгаанаар Бурхад, Будда нар дэлхийн бүх амь бодид Бурхдын хэлэхийг хүсэж буй үгийг дамжуулж өгөхийг надаас хүссэн юм, үг бүр нь тэнгэрийн нууц бөгөөд хүмүүст үнэнийг мэдүүлж, аврагдах дахин нэг боломж олгохын тулд юм.

Яагаад хүн төрөлхтөн байх болсон бэ гэхээр, орчлон ертөнц үүсэхээсээ эцсээ хүртэл Үүсэх, Тогтворжих, Доройтох, Устах гэсэн дөрвөн үе шаттай туйлын урт удаан явцыг туулдаг. Орчлон ертөнц сүйрлийнхээ эцсийн шатанд хүрмэгц, бидний амьдарч буй орчлон ертөнц гэх мэт сансрын бие дэх бүх зүйлс хормын дотор бүрэн задарна! Бүх амь бодь устах болдог!

Хүний үхлийн хувьд энэ нь зөвхөн гадаргуун энэ бие махбод доройтож, хөгшрөх явдал юм, тэгэхэд хүний сүнс (жинхэнэ өөрөө үхдэггүй) дараагийн төрөлдөө дахин төрдөг. Орчлон ертөнц үүсэх, тогтворжих, доройтох, устах жамаар явдаг бол, хүн төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх жамаар явдаг, энэ бол орчлон ертөнцийн хууль бөгөөд Бурхад ч мөн адил энэхүү явцыг туулдаг, гагцхүү энэ нь тэдний хувьд илүү урт хугацааг шаарддаг, Бурхны түвшин өндөр байх тусам явц нь илүү удаан үргэлжилдэг. Тэдний төрөх, үхэх нь зовлонгүй бөгөөд бүх явцад тэд саруул, сэргэг байдаг - тэдэнд энэ нь хувцас солихтой адил юм. Өөрөөр хэлбэл амь бодь ерөнхийдөө үхдэггүй гэсэн үг. Хэрэв орчлон ертөнц ба сансар огторгуйн биетүүд Үүсэх, Тогтворжих, Доройтох, Устахын эцсийн шатанд задарвал амь бодь дахиж төрөхгүй, бүх амь болон биет зүйлс оршин тогтнохоо больж хумхын тоос болно, бүх зүйл хоосорно. Одоо хүний ертөнцийн хувьд Үүсэх, Тогтворжих, Доройтох, Устах -ын Устах мөчлөгийн хамгийн эцсийн үе шаттайгаа тулгарч байна. Энэ эцсийн шатанд байгаа бүх зүйл сайн байхаа больсон тул сүйрэл нүүрлээд байна, тийм ч учраас өнөөгийн нийгэм маш эмх замбараагүй болсон. Хүн нинжин сэтгэлгүй болсон, садар самуун, сэтгэцийн эмгэг, хар тамхинд автах, Бурханд үл итгэх зэрэг янз бүрийн замбараагүй байдал газар авсан, сансар

ертөнцийн төгсгөлийн үе ирэхэд энэ байдал нь зайлшгүй юм, ийм цаг нэгэнт иржээ!

Бүтээгч бүх Бурхад болон нинжин сэтгэлт, гайхалтай амь бодиудыг мөн сансар ертөнцийн гайхамшигт бүтээлүүдийг эрхэмлэдэг, тийм ч учраас Доройтох үе шатны эхэн үед Бүтээгч зарим Бурхдыг дагуулж, сансар ертөнцийн хамгийн гаднах давхаргад (ерөнхийдөө Фа орны гадна гэж нэрлэдэг) буюу Бурхан байдаггүй газарт дэлхийг бүтээсэн. Дэлхий бие даан оршин тогтнох боломжгүй, үүнд заавал амь ба биологийн эргэлтийн тогтолцоог бүрдүүлэхэд зохилдсон тэнгэрийн бүтэц байх ёстой. Тиймээс Бүтээгч дэлхийн гадна том хүрээг бүтээсэн, үүнийг Бурхад Гурамсан ертөнц гэж нэрлэдэг. Эцсийн шатны аврал иртэл, хэр өндөр түвшний Бурхан байсан ч, Бүтээгчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хүслээр Гурамсан ертөнцөд орж гарч болохгүй. Гурамсан ертөнцийн хүрээнд гурван том орон байдаг: энэ дэлхий дээрх бүх амь бодиуд, тэр дундаа хүн төрөлхтөн оршдог давхаргыг “Хүслийн орон” гэж нэрлэдэг; үүний дээрх хоёр дахь орон бол “Хэлбэрт орон”; түүнээс дээрх гурав дахь орныг “Хэлбэрт бус орон” гэдэг. Орон дээшлэх тусам илүү үзэсгэлэнтэй болдог, гэхдээ тэдгээрийн алиныг ч Фа оронтой болон түүнээс дээрх Тэнгэрийн ордтой харьцуулах боломжгүй юм. Хүмүүсийн байнга ярьдаг Тэнгэр бол үнэн хэрэгтээ Гурамсан ертөнцийн Хэлбэрт орон болон Хэлбэрт бус орны хүрээнд орших тэнгэрүүд л юм. Орон болгон 10 түвшний тэнгэрээс бүрддэг учраас гурван орныг оролцуулан Гурамсан ертөнц нь 33 давхарга тэнгэртэй. Хүн Хүслийн оронд байдаг, энэ бол хамгийн доод давхарга юм, хүрээлэн буй орчин нь хамгийн хатуу ширүүн. Хүний амьдрал гашуун зовлонтой болоод богинохон, хамгийн аймшигтай нь хүний ертөнцөд зөвт зарчим гэж байдаггүй, орчлон ертөнцөд хүний зарчмууд эсрэгээрээ байдаг (Бурхдын хүнд ярьдаг Фа зарчмуудыг эс тооцвол). Тухайлбал, ялсан нь хаан болох, дэлхийг хүчээр байлдан дагуулах, хүчтэй нь баатар болох гэх мэт нь бүгд алах, дээрэмдэх замаар аливааг олж авдаг тул Бурхдын нүдэнд энэ нь зөвт зарчим биш юм. Орчлон ертөнц болон Бурхад ийм байдаггүй, харин хүний хувьд энэ нь зайлшгүй бөгөөд байх боломжтой, эдгээр нь хүний ертөнц дэх зарчмууд бөгөөд орчлон ертөнцийн зарчмуудтай харьцуулахад “урвуу зарчим” юм, тиймээс хүн Тэнгэрт буцахын тулд зөвт зарчмын дагуу “бясалгах” ёстой. Зарим хүмүүс өөрсдийгөө бусдаас илүү сайхан амьдарч байна, мөн түүнийгээ сайхан амьдрал гэж боддог ч, гагцхүү энэ нь хорвоогийн хүмүүс өөрсдийгөө өөр хоорондоо харьцуулдаг л явдал юм, үнэндээ бүгд орчлон ертөнцийн хогон дунд амьдарч байна. Гурамсан ертөнц нь тэнгэр огторгуйн хамгийн гадаргуун давхарга дээр бүтээгдсэн бөгөөд энэ нь молекул, атом зэрэг хамгийн доод, том ширхэгтэй,

хамгийн бохир элементүүдээс бүтсэн. Бурхдын нүдээр энэ бол орчлон ертөнцийн хог хаягддаг газар. Тийм ч учраас Бурхад молекулын давхаргын элементүүдийг шороо, хамгийн доод давхаргын газар гэж үздэг, мөн энэ нь шашинд яригддаг “Бурхан хүнийг шавраар бүтээсэн” гэдгийн эх утга юм, үнэндээ молекулаар бүтсэн энэ давхаргын бие бодиор хүнийг бүтээсэн.

Бурхад хүн төрөлхтнийг бүтээсэн нь Бүтээгчийн даалгавар байсан бөгөөд энэ нь өөр өөр Бурхад Түүний хэлсэн дагуу өөр өөрсдийн дүр төрхөөр хүнийг өөр өөр гадаад төрхтэйгөөр бүтээсэн. Тиймээс цагаан арьстан, шар арьстан, хар арьстан гэх мэт арьстнууд байдаг, гэхдээ гадаад төрх нь өөр өөр байдаг ч дотоод амийг нь Бүтээгч өгдөг тул бүгд нийтлэг үнэт зүйлстэй байдаг. Бүтээгч, Бурхдаар хүнийг бүтээлгэх болсны гол зорилго нь эцсийн цаг мөчид хүнийг ашиглан сансар ертөнцийн бүх амь бодийг, тэр дундаа Бурхдыг аврах явдал юм.

Тэгвэл Бүтээгч яагаад ийм доогуур, муу орчинд Бурхдаар хүн төрөлхтнийг бүтээлгэх болсон бэ? Учир нь энэ бол орчлон ертөнцийн хамгийн доод түвшин, хамгийн хэцүү газар юм, гагцхүү зовлон зүдүүрээр л бясалгаж, зовлон зүдүүрээр л нүгэлт үйлийн үрийг арилгаж чадна. Зовлон дунд хүн үргэлжийн сайхан сэтгэлтэй, талархалтай сайн хүн байж чадах нь өөрийгөө дээшлүүлж байгаа явдал юм. Түүнээс гадна аврал бол доороос дээш чиглэсэн үйл явц бөгөөд заавал хамгийн доод газраас эхлэх ёстой байдаг. Эндхийн амь зовлонтой, хүмүүсийн дундах ашиг сонирхлын зөрчил, байгалийн хатуу ширүүн орчин, хүн амьд байхын тулд бие, сэтгэлийн хувьд шаргуу хөдөлмөрлөх ёстой байдаг гэх мэт, энэ бүхэн нь амь бодид үйлийн үрээ арилгаж дээшлэх боломжийг өгдөг. Зовлон зүдүүр үйлийн үрийг арилгаж чаддаг нь дамжиггүй, зовлон ба зөрчилдөөн дунд хүн нинжин сэтгэлээ хадгалж чадвал буян хурааж, улмаар амь нь дээшилнэ.

Орчин үеийн цаг ирэхэд Бүтээгч орчлон ертөнцийн амь бодиудыг аврахын тулд хүний биеийг ашиглахыг зорьсон, тиймээс хүний биен дэх анхны аминуудын ихэнх нь хүн болж төрсөн “Бурхад”-аар солигдсон. Учир нь хүний бие махбодоор зовлон зүдүүр туулж нүгэл, үйлийн үрийг арилгаж болно, үүний зэрэгцээ урвуу зарчмуудын дунд хэрэв хүн Бурхдын айлддаг зөвт зарчмуудыг баримталж, сайхан сэтгэлийг хадгалж чадвал түүний амь дээшлэх болно. Төгсгөлийн эцсийн шат ирсэн байна, Гурамсан ертөнцийн Тэнгэрийн үүд нээгдсэн, Бүтээгч тийм хүмүүсийг аврахаар сонголтоо аль хэдийнээс хийж байна.

Орчлон ертөнцийн Үүсэх, Тогтворжих, Доройтох явцад бүх зүйлс ариун байхаа больсон, анх үүссэн үеийнх шигээ сайн биш болсон, тиймээс бүх зүйлс “устгагдах” болдог. Өөрөөр хэлбэл, сансар огторгуйн бүх зүйлс доройтож, бүх амь бодь эхэн үеийнх шигээ сайн биш болсон. Бүх амь бодиуд цэвэр ариун биш болсон, бүгд нүгэлт үйлийн үртэй болсон тул Сүйрэл нүүрлэж байна. Шашинд үүнийг “анхны нүгэл” гэж нэрлэдэг. Бүтээгч орчлон ертөнцийг аврахын тулд, олон Бурхад болон тэнгэрлэг Эздийг хүний ертөнцөд бууж ирэн, хүн болж төрөн зовлон зүдүүрийг даван туулж, дээшилж, үйлийн үрээ арилгаж, өөрсдийгөө дахин шинээр бий болгож тэнгэрт буцаж ирэхийг хүссэн. (Бүтээгч хүмүүсийг аврахын зэрэгцээ мөн орчлон ертөнцийг шинээр бүтээж байна.) Шинэ орчлон ертөнц туйлын цэвэр ариун бөгөөд үзэсгэлэнтэй, хүн энэ хатуу ширүүн орчинд нинжин сэтгэлтэй байж чадвал, орчин үеийн үзэл сурталтай тулахдаа уламжлалт үнэт зүйлсээ баримталж чадвал, Атеизм (бурхангүй үзэл), хувьслын онолын нөлөөнд үл автан Бурхдад итгэх итгэлээ хадгалж чадвал, ийм хүн аврагдаж Тэнгэрт буцах зорилгодоо хүрч чадна. Бүх эмх замбараагүй байдал бол Бурхдын сүүлчийн зохицуулалт бөгөөд зорилго нь амь бодийн аврагдаж чадах эсэхийг сорих явдал юм, үүний зэрэгцээ энэ явцад зовлон зүдүүр нь нүгэлт үйлийн үрийг арилгаж чадна, амь бодиудыг Тэнгэрийн оронд буцааж аврахын тулд энэ бүхэн хийгдэж байна.

Өөрөөр хэлбэл, энэ дэлхий дээрх хүний амь нь нийгмийн ямар нэгэн амжилтад хүрэхийн тулд зориулагдсан биш юм. Хүн ямар ч аргаар хамаагүй ашиг хонжоо хайж, тэмцэлдэх юм бол муу хүн болдог. Дэлхийд бууж ирэн хүн болсны зорилго бол үйлийн үрээ арилгаж, өөрийгөө сайн бясалгах явдал юм. Хүн энэ ертөнцөд аврал олох гэж ирсэн, хүн болж төрөн Бүтээгчийг хүлээн авралыг үзэж Тэнгэрийн орон руугаа буцахын тулд ирсэн, амьдралаас амьдралд хүлээх явцдаа буян хураах нь мөн л хүн болж төрөл олохын зорилго байсан, эмх замбараагүй ертөнц нь бүх амь бодийг зорилгод нь хүргэх учиртай юм. Гэвч зовлон зүдүүртэй тулгарахдаа зарим хүмүүс Бурхдаас тусламж гуйсан ч хүссэн зүйлээ авч чадаагүйдээ Бурхдыг үзэн ядаж эхэлсэн, улмаар тэд Бурхдын эсрэг болсон, тэр ч байтугай бүр чөтгөрийн замаар орж шинэ нүгэл, шинэ үйлийн үрийг бий болгосон. Ийм хүмүүс яаравчлан буцаж ир, Бурхнаас өршөөл гуй, тэгвэл наманчлагдаж, аврагдана. Чухамдаа хүний бүхий л амьдрал дахь хүртэх ёстой, хүртэх ёсгүй зүйл нь өнгөрсөн амьдралдаа хийсэн сайн муу үйлийн хариу байдаг, хүний өмнөх насандаа хуримтлуулсан адислал, буяны хэмжээ нь энэ насанд эсвэл дараагийн амьдралдаа хэр аз жаргалтай байхыг нь тодорхойлдог. Буян ихтэй бол, тэр нь дараагийн амьдралд нь өндөр албан тушаал, сайн цалингаар солигдож болно, эсвэл янз бүрийн эд баялаг, аз завшаан болж хувирч болно, үүнд гэр бүл нь аз

жаргалтай байх эсэх, тэр байтугай үр хүүхэд нь ямар байх нь мөн багтана. Энэ бол зарим нь баян, зарим нь ядуу, зарим нь өндөр албан тушаалтан болж, зарим нь орон гэргүй болдгийн үндсэн шалтгаан юм. Энэ нь хорон коммунист намын сурталчилсан баян ядууг тэгшитгэх үзлийн чөтгөрийн үгтэй адилгүй. Орчлон ертөнц бол шударга, амь бодь сайн үйл хийвэл адислагдана, муу үйл хийвэл хариугаа авдаг - энэ насандаа биш юмаа гэхэд хойд насандаа, энэ бол өөрчлөгдөшгүй орчлон ертөнцийн хууль! Тэнгэр, газар, Бурхад, Бүтээгчийн нэгэн адил бүх амь бодид нигүүлсэнгүй ханддаг. Тэнгэр, газар, хүн, Бурхад гээд бүгдийг Бүтээгч бүтээсэн, түүнд зарим амь бодид ивээлтэй хандана, заримд нь муу хандана гэсэн ойлголт огт байдаггүй. Урьд хийсэн сайн, муу үйлийн үр нь тухайн хүний аз жаргалтай байх, байхгүйн үндсэн шалтгаан болдог.

Алдах ба олох нь нийгэмд ердийн үзэгдэл мэт илэрдэг боловч үндсэн шалтгаан нь тухайн амины урьд хийсэн үйлийн үр дагавраас болдог. Гэхдээ ямар нэгэн юмтай байх байхгүй нь, мөн алдах ба олох нь хүн төрөлхтний нийгэмд илрэхдээ хүний нийгэмд нийцсэн байдлаар явагддаг. Тиймээс чи амьдралдаа баян ч бай, ядуу ч бай сайн үйл хийж, муу үйлийг цээрлэж, эелдэг сайхан сэтгэлтэй байж, тэнгэр Бурханаа дээдэлж, бусдад сэтгэл харамгүй тусалдаг байх хэрэгтэй. Тийм байвал адислал буян хурааж хойч насандаа ивээл хүртэнэ. Энэ насандаа их зовсон ч тэнгэр, газартаа бүү гомдолло, сайн үйл их хийж буян хурааж явбал хойд насандаа сайн сайхан байх болно гэж Хятадын эртний хөгшчүүл ярьдаг байсан. Өөрөөр хэлбэл, урьд насандаа сайн үйлс хийж буян хураагаагүй бол Бурханаас тусламж гуйн залбираад ч нэмэргүй гэсэн үг. Орчлон ертөнцөд өөрийн хууль байдаг, Бурхан ч дагаж мөрдөх ёстой. Хэрэв Бурхан хийх ёсгүй зүйл хийвэл Бурхан ч мөн адил шийтгэгдэх болно. Энэ нь хүмүүсийн бодож байгаа шиг тийм амар зүйл биш, Бурхан чамд хүссэн болгоныг чинь өгөх ёстой гэж үү? Чамд урьд насандаа хураасан буян адислал байх ёстой гэсэн нөхцөлтэй, буянаараа солино! Энэ бол орчлон ертөнцөд тогтсон хууль. Гэхдээ үнэн хэрэгтээ адислал, буян хураах нь эцсийн зорилго биш. Хүн амьдралдаа буян их хурааж өөртөө Тэнгэрт буцах замаа засах нь хамгийн чухал нь юм, харин нэг насны түр зуурын аз жаргалаар солихын тулд биш!

Багш Ли Хонжи

2023 оны нэгдүгээр сарын 20